

**БИЧИЛ УУРХАЙГААР АШИГТ МАЛТМАЛ
ОЛБОРЛОХ ТУХАЙ ГЭРЭЭ**

2023.05.31

№05

Шарын гол

“Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам”-ын 2.1, 3.1.3, 6.1.3-т заасны дагуу нэг талаас **Дархан-Уул** аймгийн **Шарын гол** сумын Засаг дарга **Б.Лхамсүрэн** (цаашид “Засаг дарга” гэх), нөгөө талаас гэрээ сунгах хүсэлт гаргасан “Хайрханы Алтан буудай” нөхөрлөл (цаашид “Бичил уурхай эрхлэгч этгээд” гэх)-ийг төлөөлж **Нөхөрлөлийн ахлагч албан тушаалтай Шаравдорж** овогтой **Ариунболд** гуравдагч талаас Монголын бичил уурхайн нэгдсэн дээвэр холбооны гүйцэтгэх, захидал **Э. Оюунболд** нар (цаашид хамтад нь “Талууд” гэх) дараах нөхцөлөөр харилцан тохиролцож 2023 оны 05 дугаар сарын 31-ны өдөр энэхүү гэрээг (цаашид “Гэрээ” гэх) **Шарын гол** суманд байгуулав.

Нэг. Ерөнхий зүйл

- 1.1. Бичил уурхай эрхлэгч этгээд нь **Шарын гол** сумын Санжинт багийн Цагаан хөтөл орших **Нийт 0.2 га** талбайд **Алт** олборлохтой холбогдсон үйл ажиллагаа эрхэлнэ.
- 1.2. Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох талаар сум (дүүрэг)-ын Засаг дарга, бичил уурхай эрхлэгч этгээдийн хооронд үүсэх харилцааг энэхүү гэрээгээр зохицуулна.

Хоёр. Сум (дүүрэг)-ын Засаг даргын эрх, үүрэг

- 2.1. Сум (дүүрэг)-ын Засаг дарга нь “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам”-ын 6 дугаар зүйлд зааснаас гадна дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ
 - 2.1.1. бичил уурхай эрхлэгч этгээдэд ногдох талбайн хэмжээг тогтоож, байршлын зургийг гэрээнд хавсаргах;
 - 2.1.2. хог хаягдлын цэгийн байршлыг тогтоох;
 - 2.1.3. бичил уурхай эрхлэгч этгээдийн олборлосон ашигт малтмалыг ангилан ялгах, баяжуулах талбайг тогтоох;
 - 2.1.4. бичил уурхайн нөхөн сэргээлтийн аргачлалын дагуу нөхөн сэргээлтийн зардлыг тооцож, бичил уурхай эрхлэгч этгээдтэй тохиролцсоны үндсэн дээр зохих хөрөнгийг сумын нөхөн сэргээлтийн дундын дансанд төвлөрүүлэх;
 - 2.1.5. бичил уурхайн ажилтнуудад (цаашид “ажилтан” гэх) зориулсан хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны сургалтыг Холбоотой хамтран зохион байгуулах;
 - 2.1.6. энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг бичил уурхай эрхлэгч этгээдээс шаардах;
 - 2.1.7. байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний гүйцэтгэлд хяналт тавих;
 - 2.1.8. хүрээлэн байгаа орчинд сөрөг нөлөөлөл үзүүлж байгаа үйл ажиллагааг зогсоох;

2.1.9.бичил уурхай эрхлэгч этгээд олборлолт явуулсан талбайг нөхөн сэргээж орон нутагт хүлээлгэн өгсөн тохиолдолд нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгийг буцаан олгох;

2.1.10.бичил уурхай эрхлэгч этгээдийн бичил уурхайн нөхөн сэргээлтийн аргачлалын дагуу хийж, сум, дүүргийн Засаг даргын томилсон комисст актаар хүлээлгэн өгсөн талбайн мэдээлэл, нөхөн сэргээлтийн тайлан мэдээг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон төрийн захиргааны байгууллагад хүргүүлж бүртгүүлэх.

Гурав.Бичил уурхай эрхлэгч этгээдийн эрх, үүрэг

3.1.Бичил уурхай эрхлэгч этгээд дараахь эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

3.1.1.бичил уурхай эрхлэгч этгээдэд олгосон талбайд ашигт малтмал олборлох үйл ажиллагаагаа явуулах;

3.1.2.ажилтнуудыг тогтоосон талбайд суурьшуулах;

3.1.3.суурьшлын талбайг тохижуулж, ахуйн болон үйлдвэрийн хог, хаягдлын цэгийг байгуулах;

3.1.4.гэрээгээр олгосон талбайд нөхөрлөл, хоршоо бус этгээдийг ажиллуулахгүй байх;

3.1.5.байгаль орчныг хамгаалж, гол, горхи, булаг шанд, уст цэгийг бохирдуулахгүй байх;

3.1.6.бичил уурхайн аюулгүй байдлын дүрмийг дагаж мөрдөх, болзошгүй ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах;

3.1.7.хууль тогтоомж, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны болон нөхөн сэргээлтийн чиглэлээр ажилтнуудад сургалт, сурталчилгаанд бичил уурхайчдыг идэвхтэй оролцуулах;

3.1.8.ашигт малтмалыг ангилан ялгах, баяжуулах үйл ажиллагааг тогтоосон талбайд гүйцэтгэх;

3.1.9.үйл ажиллагаандаа химийн хорт болон аюултай бодис хэрэглэхгүй байх, тусгай зөвшөөрөлтэй этгээдээр гүйцэтгүүлэхээс бусад тохиолдолд тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл ашиглахгүй байх;

3.1.10. Иргэний хуулийн 35 дугаар зүйлийн 35.1-д заасан нөхөрлөл, мөн хуулийн 36.4-т заасан хоршооны зохион байгуулалтад орсон бичил уурхай эрхлэгч этгээд нь ашигт малтмал олборлох үйл ажиллагаанд 3500 см3 хүртэлх багтаамжтай дотоод шаталтат хөдөлгүүр бүхий 2-оос илүүгүй механизмыг ашиглах;

3.1.11. Бичил уурхайн нөхөн сэргээлтийн аргачлалын дагуу эрх бүхий этгээдийн тогтоосон байгаль орчны нөхөн сэргээлтийн зардалд шаардагдах 5.000000 /турван сая төгрөгийг/ Төрийн сангийн 100190455402 /Да.Шарын гол байгаль НСбарьцаа/ дансанд төвлөрүүлэх;

3.1.12.нөхөн сэргээлтийн дундын санд төвлөрүүлсэн хөрөнгийг олборлолт явуулсан талбайн нөхөн сэргээлтэд зарцуулах;

3.1.13.бичил уурхайн нөхөн сэргээлтийн аргачлалын дагуу олборлолт явуулсан талбайдаа нөхөн сэргээлт хийж сүм, дүүргийн Засаг даргын томилсон комисст актаар хүлээлгэж өгөх;

3.1.14.олборлосон ашигт малтмалыг хууль тогтоомжийн дагуу худалдан авах эрх бүхий хуулийн этгээд, Үнэт металл, үнэт чулууны арилжаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий этгээдэд олборлосон үнэт металл, үнэт чулууг худалдах;

3.1.15.ажилтнуудтай хөдөлмөрийн гэрээ байгуулах, холбогдох хууль тогтоомжийн дагуу орлогын албан татвар төлөх.

3.2.Бичил уурхай эрхлэгч этгээд нөхөн сэргээлт хийж, талбайг хүлээлгэн өгсний дараа ашигт малтмал олборлох өргөдөл дахин гаргах.

Дөрөв.Мэргэжлийн холбооны үүрэг

4.1.Төрийн захиргааны байгууллага, сүм, дүүрэгтэй хамтран баталсан хөтөлбөрийн дагуу Бичил уурхайн үндсэн сургалтын хөтөлбөрийн дагуу бичил уурхайн эрх зүйн зохицуулалт, хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй, ашигт малтмалын гарал үүсэл, магадлан шинжилгээ, нөхөн сэргээлтийн сургалтыг нөхөрлөлийн гишүүдэд зохих журмын дагуу зохион байгуулах, гэрчилгээ олгох.

4.2.Бичил уурхайчдад гэрчилгээ олгох.

4.3.Энэхүү гэрээний хэрэгжилтэд тогтмол хяналт тавьж гэрээний хэрэгжилтийн үнэлгээг жил бүр хийх, хэрэгжилтийн үнэлгээний мэдээллийг Ашигт малтмал газрын тосны газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газарт хургуулэх.

4.4.Нөхөн сэргээлтийг сумаас томилсон нөхөн сэргээлт хүлээн авах комисс **2023** оны **10** дугаар сарын **20**-ны өдрөөс **10** дугаар сарын **25**-ны өдрийн дотор хүлээн авна.

4.5.Бичил уурхайн үйл ажиллагаанд хяналт тавих графикийг Засаг даргын зүгээс, Бичил уурхайчдын зүгээс ашиглалтын үйл ажиллагаа явуулах үйл ажиллагааны графикийг гаргаж батлуулах

4.6.Талууд энэхүү гэрээний биелэлтийг **2023** оны **11** сарын **10**-нд хамтран дүгнэж, аймгийн Засаг даргад дараа оны 1 дүгээр сард багтаан тайлагнана.

Тав.Маргаан шийдвэрлэх

5.1.Талууд гэрээтэй холбоотой үүссэн аливаа маргаантай асуудлыг харилцан тохиролцох замаар шийдвэрлэнэ.

5.2. Талууд тохиролцоонд хүрээгүй тохиолдолд Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу маргааныг шийдвэрлэнэ.

Зургаа. Гэрээний хүчин төгөлдөр болох

6.1. Энэхүү гэрээ нь 2023 оны 05 сарын 31 өдрөөс 2023 оны 12 сарын 10 өдөр хүртэл хугацаанд хүчин төгөлдөр үйлчилнэ.

6.2. Бичил уурхайгаар ашигт малтмал олборлосон талбайд нөхөн сэргээлт хийж орон нутагт хүлээлгэж өгснөөр энэхүү гэрээний үүрэг дуусгавар болно.

6.3. Энэхүү гэрээг 3 хувь үйлдэж талууд тус бүр нэг хувийг хадгална.

Долоо. Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах

7.1. Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр шийдвэрлэнэ.

7.2. Энэхүү гэрээнд оруулсан нэмэлт, өөрчлөлт нь түүний нэгэн адил хүчинтэй байх бөгөөд гэрээний салшгүй хэсэг болно.

Гэрээ байгуулсан:

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ШАРЫН ГОЛ СҮМЫН ЗАСАГ ДАРГА
ДАРААНЫ АЙМГИЙН ШАРЫН ГОЛ СҮМЫН ЗАСАГ ДАРГА

Б. ЛХАМСҮРЭН
Б. ЛХАМСҮРЭН

МБУНД ХОЛБООНЫ ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Э. ОЮУНБОЛД

"ХАЙРХАНЫ АЛТАН БУУДАЙ НӨХӨРЛӨЛИЙН АХЛАГЧ
ХАЙРХАНЫ АЛТАН БУУДАЙ НӨХӨРЛӨЛИЙН АХЛАГЧ

Б. АРИУНБОЛД

